



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Шагналд уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, “Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам”-ыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

"МОНГОЛ УЛСЫН АРДЫН ЖҮЖИГЧИН ЦОЛ"-ООР:

- | | |
|------------------------|--|
| 1. Лхамжавын Цэндсүрэн | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны өндөр настан |
|------------------------|--|

"МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ"-ООР:

- | | |
|------------------------|---|
| 1. Тулгаагийн Бат-Очир | Монголын Саран ээж нийгэмлэгийн Ерөнхий менежер |
|------------------------|---|

"ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН"-ООР:

- | | |
|--------------------------|---|
| 1. Баасанжавын Бадамханд | Нийслэлийн Эрүүл Мэндийн газрын Хүүхэд, өсвөр үеийн асуудал хариуцсан мэргэжилтэн |
| 2. Мандширын Болд | Нийслэлийн Ахмадын хорооны дэд дарга |

"ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ"-ААР:

- | | |
|-----------------------------|--|
| 1. Бадамсүрэнгийн Баатарсүх | Нийслэлийн Эрүүл Мэндийн газрын Мэргэжилтэн |
| 2. Алгаагийн Балдандорж | Чингэлтэй дүүргийн Эрүүл Мэндийн төвийн Ахлах сувилагч, дүн бүртгэгч |

1150100059

- | | |
|-------------------------------|---|
| 3. Даваагийн Болдбаатар | Нийслэлийн Эрүүл Мэндийн газрын Мэргэжилтэн |
| 4. Цэдэвдоогийн Лувсанданзан | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны ахмад настан, Хэсгийн ахлагч |
| 5. Мэндбаярын Оюунтунгалаг | Нийслэлийн Эрүүл Мэндийн газрын бичээч, бичиг хэрэг, нярав |
| 6. Авайгийн Рас | Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо, Улсын бүртгэгч |
| 7. Дамдиндоржийн Сайханжаргал | "Монгол Экспресс" ХХК-ний Ахлах менежер |
| 8. Цанжидын Сонгиносүрэн | Нийслэлийн Эрүүл Мэндийн газрын мэргэжилтэн |
| 9. Бадарчийн Уламбаяр | Чингэлтэй дүүргийн Эрүүл Мэндийн төвийн Төлөвлөлт, хамтын ажиллагааны менежер |

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Зуны түр худалдаа, үйлчилгээний байршил,
үйл ажиллагааны чиглэл тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 33 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Өрхийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайд зуны түр худалдаа, үйлчилгээ эрхлэх 37 байршил, үйл ажиллагааны чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. Зуны түр худалдаа, үйлчилгээ эрхлэх хугацааг 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэл байхаар тогтоосугай.

3. Зуны түр худалдаа эрхлэхэд тавигдах шалгуур, шаардлагыг хангасан, хүсэлт гаргасан Чингэлтэй дүүргийн харьяат иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай батлагдсан байршил, чиглэл, хугацааны дагуу гэрээ байгуулж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдалд байнгын хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

4. Өрхийн хөгжлийг дэмжих хүрээнд зуны түр худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг зуны түр худалдааны хог хаягдал гаргасны төлбөр хураамжаас түр чөлөөлсүгэй.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100062

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын ...-ны
өдрийн дугаар тогтоолын хавсралт



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
ЗУН ТҮР ХУДАЛДАА ГАРГАХ БАЙРШЛЫН ЖАГСААЛТ

№	Хороо дугаар	Байршил	Үйл ажиллагааны чиглэл	
1	1 дүгээр хороо	40, 41 дүгээр байр, Нүүдэлчин цайны газрын зүүн хойно	Хүнсний ногооны худалдаа	
			Жимсний худалдаа	
			Зайрмаг	
		Ардын автобусны буудал	Зайрмаг	
			Өтгөрүүлсэн жүүсний худалдаа	
			Жимсний худалдаа	
		Төрийн өмчийн 4 дүгээр байрны урд, автобусны буудал	Хүнсний ногооны худалдаа	
			Ус ундааны худалдаа	
		Мөнгөн завьяа автобусны буудал	Өтгөрүүлсэн жүүсний худалдаа	
			Зайрмаг	
		Капитрон банкны зүүн талд	Зайрмаг	
			Өтгөрүүлсэн жүүс худалдаа	
Нүдний шилний худалдаа				
Жимсний худалдаа				
Түгээмэл төвийн урд	Зайрмаг			
	Ус ундааны худалдаа			
Орон сууцны хорооллол дунд /1,3,12,14 дүгээр байрнуудын дунд/	Хүнсний ногооны худалдаа			
2	2 дугаар хороо	Голомт банкны урд	Зайрмаг	
			Жимсний худалдаа	
			Хүнсний ногооны худалдаа	
		40 мянгатын 21, 22, 23 дугаар байрнуудын дунд	Хүнсний ногооны худалдаа	
3	3 дугаар хороо	Урт цагааны зүүн талд	Нүдний шилний худалдаа	
			Квас	
			Зайрмаг	
			Жимсний худалдаа	
			Ус ундааны худалдаа	
			Хүнсний ногооны худалдаа	
			Айрагны худалдаа	
			ЖДҮЭрхлэгчдийн барааны худалдаа	
		Ив роше дэлгүүрийн урд /76 дугаар байр/	Жимсний худалдаа	
			Зайрмаг	
		Орон сууцны хороолол дунд	2 дугаар дөчин мянгатын 2, 8 дугаар байрнуудын дунд	Хүнсний ногооны худалдаа
			2 дугаар дөчин	Хүнсний ногооны худалдаа
			Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа	

			мянгатын 11, 12 дугаар байрнуудын дунд	
			Тавин мянгатын 19, 20 дугаар байрнуудын дунд	Хүнсний ногооны худалдаа
4	4 дүгээр хороо	Хаан банкны зээлийн төвийн үүдэнд		Жимсний худалдаа
				Ус ундааны худалдаа
		Зоос гоёлын үүдэнд		Зайрмаг
				Хүнсний ногооны худалдаа
Орон сууцны хороолол дунд	18 дугаар байны зүүн талд, модны доор		Ус ундааны худалдаа	
			Зайрмаг	
			41 дүгээр байрны зүүн талд	Хүнсний ногооны худалдаа
5	5 дугаар хороо	Тусгаар тогтнолын талбай		Цагаан идээний худалдаа
				Удирдлагатай автомат хүүхдийн машин
				Хавчаахай
				Хүүхдийн эргэдэг онгоц, вагон, савлуур
				Мини сагс
				Эргэдэг дугуй
		Тэнгис кино театрын буудал дээр		Дугуй
				Зайрмаг
				Зайрмаг
		Теди төвийн урд талд		Ус ундааны худалдаа
				Жимсний худалдаа
				Өтгөрүүлсэн жүүсний худалдаа
Орон сууцны хорооллол дунд	Тэнгис кино театрын орчимд		Квас	
			Зайрмаг	
		4, 5 дугаар байруудын дунд	Жимсний худалдаа	
6	6 дугаар хороо	56/31 дүгээр байрны зүүн хойно		Хүнсний ногооны худалдаа
				Жимсний худалдаа
		45 дугаар байрны урд талд		Хүнсний ногооны худалдаа
				Хүнсний ногооны худалдаа
Орон сууцны хорооллол дунд /БТ-23, 31 дүгээр байрнуудын дунд/			Хүнсний ногооны худалдаа	
7	12 дугаар хороо	Гахайн байрнаас хойшоо, автобусны буудлын ойролцоо		Хүнсний ногооны худалдаа
8	18 дугаар хороо	Сайн ломбардны үүдэнд		Хүнсний ногооны худалдаа
		Хорооны хойд талд, Алтансүйх дэлгүүрийн орчимд		Жимсний худалдаа
		Шадивлангийн зуслан		Хүнсний ногооны худалдаа
				Жимсний худалдаа
				Зайрмаг
				Хоол үйлдвэрлэл /хуушуур, шарсан тахиа, чанасан толгой, шорлог, айраг/

9	19 дүгээр хороо	Салхит	Ус ундааны худалдаа
			Хүүхдийн тоглоомын худалдаа
			Хүнсний ногооны худалдаа
			Жимсний худалдаа
			Зайрмаг
			Хоол үйлдвэрлэл /хуушуур, шарсан тахиа, чанасан толгой, шорлог, айраг/
		Ус ундааны худалдаа	
		Хүүхдийн тоглоомын худалдаа	
		Ар согоотын зуслан	Хүнсний ногооны худалдаа
			Жимсний худалдаа
			Зайрмаг
			Хоол үйлдвэрлэл /хуушуур, шарсан тахиа, чанасан толгой, шорлог, айраг/
			Ус ундааны худалдаа
			Хүүхдийн тоглоомын худалдаа
		Шадивлангийн зуслан	Хүнсний ногооны худалдаа
			Жимсний худалдаа
			Зайрмаг
			Хоол үйлдвэрлэл /хуушуур, шарсан тахиа, чанасан толгой, шорлог, айраг/
			Ус ундааны худалдаа
			Хүүхдийн тоглоомын худалдаа
		Зуун модны зуслан	Хүнсний ногооны худалдаа
			Жимсний худалдаа
			Зайрмаг
			Хоол үйлдвэрлэл /хуушуур, шарсан тахиа, чанасан толгой, шорлог, айраг/
			Ус ундааны худалдаа
			Хүүхдийн тоглоомын худалдаа
		Яргайтын зуслан	Хүнсний ногооны худалдаа
			Жимсний худалдаа
			Зайрмаг
			Шарсан тахиа
			Ус ундааны худалдаа
			Хүүхдийн тоглоомын худалдаа
		Яргайтын богино	Хүнсний ногооны худалдаа
			Жимсний худалдаа
			Зайрмаг
			Хоол үйлдвэрлэл /хуушуур, шарсан тахиа, чанасан толгой, шорлог, айраг/
			Ус ундааны худалдаа
			Хүүхдийн тоглоомын худалдаа
		Жигжидийн зуслан	Хүнсний ногооны худалдаа
			Жимсний худалдаа
			Зайрмаг
			Хоол үйлдвэрлэл /хуушуур, шарсан тахиа, чанасан толгой, шорлог, айраг/
Ус ундааны худалдаа			
Махны худалдаа			

		<p>Хүүхдийн тоглоомын худалдаа</p> <p>Жимс Ус ундаа Айраг Зайрмаг Квас Хүнсний ногоо Хоол үйлдвэрлэл /хуушуур, шарсан тахиа, чанасан толгой, шорлог, айраг/ Өтгөрүүлсэн жүүс</p> <ul style="list-style-type: none"> ❖ Хүүхдийн тоглоомын худалдаа ❖ Хүүхдийн тоглоомын үйлчилгээ ❖ Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний худалдаа
Нийт 37 байршилд		



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

**Нийслэлийн Чингэлтэй дүүргийн
гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын
баримт бичиг батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Улсын Их Хурлын 2011 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг хавсралт ёсоор баталсугай.
2. Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусган зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга /Ж.Эрдэнэбат/, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

1150100003

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 06 дугаар сарын
13-ны өдрийн 19 дугаар тогтоолын хавсралт

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн гадаад харилцааг
хөгжүүлэх бодлогын баримт бичиг

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын хүрээнд дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны зарчим, чиглэлийг тодорхойлох, дэлхийн улс орнуудтай найрсаг харилцаа тогтоож, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, тэдний тэргүүлэх менежмент, шинэ техник, технологи, сайн туршлагыг дүүрэг, орон нутагтаа нэвтрүүлэх, харилцаа, хамтын ажиллагаанд түшиглэн дүүргийн эдийн засаг, нийгмийн болон бусад салбарыг хөгжүүлэх, олон улсын байгууллага, хамтын нийгэмлэг, холбоонд эвлэлдэн нэгдэх, байр сууриа бэхжүүлэх, дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагуудын гадаад харилцааны нэгдмэл байдлыг хангах, гадаад бодлого, үйл ажиллагаагаа Улс, Нийслэлээс баримталж буй гадаад бодлоготой уялдуулан зохицуулахад энэхүү бодлогын баримт бичгийн зорилго оршино.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдал болон Гадаад бодлогын үзэл баримтлал, дүүргийн нийт иргэдийн нийтлэг эрх ашигт нийцсэн, Улс, Нийслэл, дүүрэг, орон нутгийн бодлого, зорилт, нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлд тулгуурлана.

1.2. Нийслэлийн Чингэлтэй дүүрэг нь гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ эв найрамдлыг эрхэмлэх, залгамж чанарыг хадгалах, нэгдмэл, тогтвортой байдлыг хангах, эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмуудыг баримтлан ажиллана.

1.3. Дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон нутгийн захиргааны байгууллагууд нь гадаад улс орнуудтай харилцаа тогтоох, хамтын ажиллагааг эхлүүлэх, харилцан айлчлал хийх, гэрээ, хэлэлцээр байгуулахдаа энэхүү бодлогын баримт бичгийг баримтлах бөгөөд эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох хөтөлбөр, дүрэм, журмыг мөн дагаж мөрдөнө.

1.4. Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлого, зорилт, тэргүүлэх болон ерөнхий чиглэлийг Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, дүүрэг, орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, харилцаа, хамтын ажиллагаа бүхий улс орнууд болон бусад улс орнуудын гадаад бодлогын нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөн тогтоож болно.

1.5. Харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд гадаад улс орны хот, дүүрэг, олон улсын байгууллага, хамтын нийгэмлэг, холбоодтой байгуулсан гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэг, амлалтаа чанд сахин биелүүлнэ.

Хоёр. Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын чиглэл

2.1. Гадаад улс орнуудын ижил төстэй байгууллага, олон улсын болон хамтын нийгэмлэг, холбоодтой нийгэм, эдийн засаг, гадаад харилцаа, спорт, соёл урлагийн салбарыг хөгжүүлэхэд хамтран ажиллана.

2.2. Харилцаа, хамтын ажиллагаа бүхий БНХАУ, ОХУ, БНСУ, БНТУ, Япон Улсын хот, дүүргүүд болон олон улсын байгууллага, хамтын нийгэмлэг, холбоодтой тогтоосон найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэх, гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэг, амлалтаа харилцан хэрэгжүүлэх, хамтын ажиллагааны салбар, хүрээгээ өргөжүүлэн тэлэх, хамтын ажиллагаа бүхий улс орнуудын соёл урлаг, эдийн засаг, худалдаа, үйлдвэрлэл, техник, технологийн онцлогийг харилцан сурталчилна.

2.3. БНСВУ, БНИУ, Унгар зэрэг бусад улс орнуудын хот, дүүрэг, холбоо, хамтын нийгэмлэгийн байгууллагуудтай харилцаа тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэх, цаашид эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт хамтран ажиллана.

Гурав. Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын тэргүүлэх зорилт:

3.1. Бүс нутгийн болон бусад улс орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд дүүрэг, орон нутагт тулгамдсан дараах асуудлуудыг шийдвэрлэхийг тэргүүлэх зорилтоо болгоно. Үүнд:

- Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах;
- Хот тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх;
- Гэр хорооллыг дахин төлөвлөх;
- Ажилгүйдэл, ядуурлыг арилгаж, ажлын байрыг нэмэгдүүлэх;
- Гэмт хэрэг, зөрчил, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх;
- Авто замын түгжрэлийг бууруулах;
- Дэд бүтэц, аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Жижиг дунд үйлдвэрлэл, худалдааг хөгжүүлэх,
- Бизнес эрхлэгчдийг дэмжих;

3.2. Тэргүүлэх зорилтыг хэрэгжүүлэхдээ дэлхийн өндөр хөгжилтэй улс орон болон, хөгжиж буй орнуудын туршлагыг судлах, төсөл, хөтөлбөрт хамрагдах, хамтран хэрэгжүүлэх, сайн туршлага, инноваци, ноу хауг нэвтрүүлэх, шинэ техник технологийг дүүрэг, орон нутагтаа нутагшуулах замаар шийдвэрлэнэ.

Дөрөв. Дүүргийн гадаад харилцааг хөгжүүлэх бодлогын ерөнхий зорилтууд:

Зорилт 1: Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:

4.1. Дүүргийн хөгжил дэвшилд эерэгээр нөлөөлөхүйц гадаад орчныг бүрдүүлэх, харилцаа, хамтын ажиллагаа бүхий улсуудын хот, дүүрэг, олон улсын

байгууллагатай тогтоосон харилцаанд идэвх, санаачлагтай хандах, дэлхийн өндөр хөгжилтэй улс орон болон хөгжиж буй орнуудын ижил, төстэй байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааны чиглэлийг тогтоох, харилцан туршлага судлах замаар тэдний сайн туршлага, шинэ техник технологийг дүүрэг, орон нутагтаа нэвтрүүлнэ.

4.1.1. Дүүргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.1.2. “Сайн хөрш”-ийн харилцаат ОХУ, БНХАУ-ын бусад хот, дүүргүүдийн ижил төстэй байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааны чиглэлийг тогтоох, стратегийн түншлэлийн хүрээнд дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага, ажилтан, албан хаагчдыг мэргэшүүлэх, харилцан туршлага солилцуулах, давтан сургах зэрэг асуудлуудыг салбар бүрт хэрэгжүүлнэ.

4.1.3. “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд БНСУ, БНТУ, БНСВУ, Япон, Унгар зэрэг улсуудын хот, дүүргүүдийн ижил төстэй байгууллагуудтай харилцаа тогтоож, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

4.1.4. Олон Улсын байгууллага, хамтын нийгэмлэг, бусад холбоод, төрөлжсөн байгууллагуудтай харилцаа тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэх, үр өгөөж бүхий төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, дүүрэг, орон нутагтаа хамтран хэрэгжүүлнэ.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны гадаад бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт:

- Гадаад улс орнуудын хот, дүүргүүдтэй тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа өргөжин тэлсэн байна
- Дүүргийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхүйц гадаад улс, орнуудын хот, дүүргүүдтэй харилцаа тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлсэн байна.
- Олон улсын болон хамтын нийгэмлэг, бусад холбоодтой харилцаа холбоо тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлсэн байна.
- Гадаад улс орнуудын сайн туршлага, инноваци, техник технологи, ноу хауг дүүрэг орон нутгийн болон бусад салбар байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээнд нэвтрүүлсэн байна.

Зорилт 2: Эдийн засгийн чиглэлээр:

4.2. Дүүргийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад гадаад улс орнуудын эдийн засгийн тэргүүн технологи, менежментийг нэвтрүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад зах зээлд сурталчлах, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татах, бизнес эрхлэгчдийг гадаад улс орнуудын ижил төрлийн байгууллагуудтай холбон зуучлах зэргээр дүүргийн ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлнэ.

4.2.1. Дүүргийн эдийн засгийн гадаад харилцааны бодлогын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.2.2. Харилцаа, хамтын ажиллагаа бүхий гадаад улс орнууд болон бусад улс оронд зохион байгуулагдах худалдаа, үйлчилгээний үзэсгэлэн, яармагт дүүргийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг оролцуулах, бүтээгдэхүүн, үйлчилгээг нь гадаад улс, оронд сурталчлахад дэмжлэг үзүүлнэ.

4.2.3. Дүүргийн “Чингэлтэйд үйлдвэрлэв” жижиг, дунд үйлдвэрлэлийн брэнд бүтээгдэхүүнийг харилцаа, хамтын ажиллагаа бүхий гадаад улс орнууд болон бусад улс оронд экспортлох асуудлыг гэрээ, хэлэлцээрийн түвшинд дэмжиж ажиллана.

4.2.4. Дүүргийн гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд тусгагдсан асуудлуудыг шийдвэрлэхэд гадаад улс орны болон олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, шууд болон шууд бус хөрөнгө оруулалтыг татах, хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд хамтран хэрэгжүүлнэ.

4.2.5. Дүүргийн аж ахуй нэгж байгууллага, бизнес эрхлэгчдийг гадаад зах зээлд өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлсэн бизнесийн таатай орчин бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

4.2.6. Дүүргийн эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхүйц төсөл, хөтөлбөрүүдийг иргэдийнхээ нийтлэг эрх, ашгийг хангах зорилгод нийцүүлэн хэрэгжүүлнэ.

Эдийн засгийн гадаад бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт:

- Дүүргийн эдийн засгийн тогтвортой өсөлт нэмэгдсэн байна.
- Ард иргэдийн амьжиргааны түвшин дээшилж, гадаад харилцааны үр нөлөө нэмэгдсэн байна.
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний экспортын тоо өссөн байна.
- Гадаадын хөрөнгө оруулалт, тусламж нэмэгдсэн байна.

Зорилт 3: Нийгмийн хөгжлийн чиглэлээр:

4.3. Гадаад улс орнуудын тэргүүн туршлага, менежментийг судлах, үйлчилгээндээ нэвтрүүлэх замаар дүүргийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг олон улсын жишиг, шаардлагад ойртуулах, гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд нийгмийн салбарын үйлчилгээ, боловсон хүчнийг хөгжүүлнэ.

4.3.1. Дүүргийн нийгмийн хөгжлийн гадаад харилцааны бодлогын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3.2. Дүүргийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын боловсон хүчин, мэргэжилтнүүдийг тухайн салбарт тэргүүлэх туршлагатай харилцаа, хамтын ажиллагаа бүхий улс орон болон бусад улс орны ижил, төстэй байгууллагад туршлага судлуулах, дадлагжуулан сургах, гадаадын өндөр мэргэжлийн болон мэргэшсэн багш, эрдэмтдийг урилгаар ажиллуулах зэргээр салбар бүрт мэргэшсэн, чадварлаг боловсон хүчин бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

4.3.3. Гадаадын их, дээд сургууль, институт, курс, судалгааны байгууллагуудтай харилцаа тогтоож, боловсролын салбарыг хөгжүүлэхэд хамтын ажиллагаагаа чиглүүлнэ.

4.3.4. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагч, их, дээд сургуулийн оюутнуудыг харилцаа, хамтын ажиллагаа бүхий улс орнууд болон бусад улс орны хот, дүүргүүдийн их, дээд сургуулиудад зуучлах, тэтгэлгээр суралцуулах, сурагч, оюутан солилцооны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлнэ.

4.3.5. Гадаадын улс, хот, дүүргийн болон олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамрагдаж, дүүргийн болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах, тоног төхөөрөмжийг нь шинэчлэн, сайжруулах, бүх төрлийн лаборатори байгуулах, өвчтөн эмчлүүлэх зэрэг саналуудыг дэмжиж, зуучлана.

Нийгмийн хөгжлийн гадаад бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт:

- Дүүргийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг олон улсын жишиг, шаардлагад нийцүүлсэн байна.
- Хөгжлийн ахиц дэвшилд хүрсэн улс, орны сайн туршлагыг нийгмийн салбарын үйл ажиллагаа, үйлчилгээнд нэвтрүүлсэн байна.
- Дүүргийн харьяаны ерөнхий боловсролын сургуулийн сурагч, их дээд сургуулийн оюутнуудыг гадаадын хамтын ажиллагаатай болон бусад улс, хот, дүүргийн их дээд сургуулиудад тэтгэлгээр суралцуулж, сурагч, оюутан солилцооны хөтөлбөрт хамруулсан байна.

Зорилт 4: Соёл урлаг, спортын чиглэлээр:

4.4. Гадаад улс орнуудтай соёл урлаг, спортын салбарт хамтран ажиллах, олон улсын тэмцээн, уралдаан, наадамд урлаг, спортоор манлайлагч дүүргийн хүүхэд, залуучуудыг оролцуулах, дадлагажуулах, туршлага судлах зэрэг саналуудыг дэмжих, харилцаа, хамтын ажиллагаа бүхий улс орнуудын урлаг, соёлын өвийг харилцан сурталчилах, соёлын солилцооны хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлнэ.

4.4.1. Дүүргийн соёл урлаг, спортын гадаад бодлогын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

4.4.2 Соёл урлаг, спорт болон олон нийтийн хэвлэл, мэдээллийн чиглэлийн олон улсын байгууллагатай харилцаа тогтоож, хамтран ажиллана.

4.4.3 Монгол туургатан бүхий улс орнуудын хот, дүүргүүдтэй соёл, хүмүүнлэгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, Монгол хэл, соёл, уламжлалаа хадгалан хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

4.4.4. Олон улсын урлаг, спортын арга хэмжээ, тэмцээн, уралдаанд урлаг, спортоор манлайлагч дүүргийн хүүхэд, залуучуудын оролцох боломжийг бүрдүүлэх, харилцаа хамтын ажиллагаа бүхий улс орнуудын хот, дүүргүүдтэй хамтран урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна.

Соёл урлаг, спортын гадаад бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

- Харилцаа, хамтын ажиллагаа бүхий улс орнуудтай хамтран хэрэгжүүлэх соёлын солилцооны хөтөлбөр, соёл урлаг, спортын салбар дахь гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжсөн байна.
- Монгол туургатан бүхий улс орнуудад Монгол хэл, соёл уламжлалаа тээгч, хадгалан хамгаалах иргэдийн тоо өссөн байна.
- Олон улсын урлаг, спортын арга хэмжээ, тэмцээн, уралдаанд оролцох дүүргийн хүүхэд, залуучуудын тоо өссөн байна.
- Олон улсын урлаг, спортын тэмцээн, уралдаанд оролцогчдын амжилт дээшилсэн байна.
- Хамтын ажиллагаа бүхий улс орны хот дүүрэгтэй хамтарсан урлаг, спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулж хэвшсэн байна.

Тав. Гадаад бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр

5.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө

5.2 Хамтын ажиллагаатай болон хандивлагч улс, хот, дүүрэг, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгө

5.3 Бусад